

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайланг (Хавсралт 1) хавсалтаар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Хоёр. Компанийн 2016 оны санхүүгийн тайланг (Хавсралт 2) хавсалтаар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Гурав. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулгай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/02

Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.2 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (С.Нэргүй), Дэд захирал бөгөөд Ерөнхий Инженер (Б.Батжаргал), Ерөнхий Нягтлан бодогч (М.Гэрэлмаа) нарт даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/03

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2015 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн үйл ажиллагаа, санхүүнийн тайлан, төлөвлөгөө Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн Компанийн нийт энгийн хувьцаа эзэмшигчдэд 2016 оны үйл ажиллагаагаар ногдол ашиг олгохгүй байхаар тогтоосугай.

Хоёр. Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах үүргийг Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дарга (Л.Балган)-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/04

Улаанбаатар хот

Аудитын компани сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10. 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ийг аудитороор сонгон томилж, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Аудитын хорооны дарга (Л.Балган), Гүйцэтгэх захирал (С.Нэргүй) нарт олгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 3-р сарын 20-ны өдөр

Дугаар 03/05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2017 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11 цагт "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн жилийн санхүүгийн тайлан болон түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах, (ii) Компанийн ТУЗ-өөс баталсан 2017 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх (iii) Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх, (iv) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, (v) Компанийн ТУЗ-ийн 2017-2018 оны цалин урамшуулал болон зардлыг батлах.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 4-р сарын 7-ны өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2017 оны 4-р сарын 7-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2016 оны санхүүгийн тайлан тэнцэл болон, Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөө, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Г.Бэхбатыг томилсугай. Тооллогын комиссын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Балган, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Бэхбат, Н.Эрдэнбат, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Баярманла нарыг тус тус томилсугай.

Долоо. Саналын хуудасын агуулгыг хавсралт ёсоор батлан, саналын хуудсыг авах сүүлчийн өдрийг 2017 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөр тогтоосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:

